

# ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНД УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШҮҮГЧИД НЭР ДЭВШИГЧИЙГ ТАНИЛЦУУЛСАН ТУХАЙ

2019 оны 12 дугаар сарын 04-ний өдөр

Улаанбаатар хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын дээд шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн нэр дэвшигч Болдын Амарбаясгалангийн танилцуулгыг Шүүхийн ерөнхий зөвлөл 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн.

Хууль зүйн байнгын хороо 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасан журмын дагуу Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн асуудлыг хэлэлцлээ. Байнгын хорооны хуралдаанд нэр дэвшигчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Э.Батбаяр танилцууллаа.


Дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Л.Болд, Ц.Гарамжав, Ц.Нямдорж, О.Батнасан, Ш.Раднаасэд, Х.Нямбаатар, Л.Мөнхбаатар нар Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга болон нэр дэвшигчээс асуулт асууж, Улсын Их Хурлын гишүүн Ц.Нямдорж нэр дэвшигчид хандаж үйл ажиллагаандаа шударга ёсыг дээдлэн ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Х.Нямбаатар нар Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан холбогдох хуульд өөрчлөлт оруулах асуудалд Шүүхийн ерөнхий зөвлөлийг идэвх, санаачилгатай ажиллах талаар санал хэлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасан журмын дагуу Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Болдын Амарбаясгаланг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулсан болно.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Х.НЯМБААТАР

# ТАНИЛЦУУЛГА

/Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд нэр дэвшигч/

- |   |   |   |
|---|---|---|
| 1.Овог, нэр:  | Болдын АМАРБАЯСГАЛАН  |  |
| 2.Хэзээ, хаана төрсөн:  | 1974 онд Улаанбаатар хотод төрсөн.  |   |
| 3.Нас, хүис:  | 45 настай, эрэгтэй.   |   |
| 4.Үндэс угсаа:  | Халх.   |   |
| 5.Ам бүлийн байдал:   | Эцэг, эхийн хамт амьдардаг.   |   |
| 6.Хэзээ, хаана, ямар сургууль төгссөн мэргэжил, эрдмийн зэрэг, цол: | -1981-1991 онд Оросын 2 дугаар дунд сургууль;<br>-1991-1995 онд Монгол Улсын Их сургуулийн хуулийн анги;<br>-1998-1999 онд Батлан хамгаалахын их сургуулийн Хууль зүйн ухааны магистр;<br>-2013 онд Хууль зүйн ухааны доктор.   |   |
| 7.Ажилласан байдал:   | -1995-1998 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуульд эрдэм шинжилгээний ажилтан;<br>-1998-2007 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуульд багш;<br>-1999 оноос одоог хүртэл өмгөөлөгч;<br>-2007-2013 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуульд ахлах багш;<br>-2013-2016 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуульд дэд профессор;<br>-2017 оны 09 дүгээр сараас Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуульд профессор. |   |
| 8.Гадаад хэл:   | Орос, Герман, Англи, Япон хэлтэй.   |   |

---ooOoo---